

ТАНИЛЦУУЛГА

Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журмын төсөл

Төрийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11-д "...Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах, холбогдох журмыг батлах" гэж заасны дагуу "Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-ын төслийг боловсруулан танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлаар 2002 онд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль батлагдсаны дагуу Улсын Их Хурлын 2003 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 13 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-г баталж, 2003 оноос 2019 оныг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж ирсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.12-т "Төрийн албан ерөнхий болон тусгай шалгалт /тухайн албан тушаалын/өгөх болзол, журмыг Төрийн албаны зөвлөл батална" гэсний дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам" батлагдсан.

Мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11-т "...төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах, холбогдох журмыг батлах" гэж заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор "Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам"-ыг баталсан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38.-д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;" гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг заасан байдаг.

Хэдийгээр төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагч нь төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтан боловч дээр дурдсан хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг хүний нөөц болон санхүүгийн эрх мэдэл бүхий албан тушаалтан тул Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журмаар шалгалтын агуулга, хэлбэр, үнэлгээ өгөх нь Төрийн албаны тухай хуулийн чадахуйн зарчимд нийцэхгүй байгаа тухай Төрийн албаны зөвлөлийн ажлын

албаны даргын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан комиссын тайланд санал байдлаар орсон байна.

Өөрөөр хэлбэл байгууллагыг удирдах албан тушаалтныг боловсрол, туршлагын харгалзан үзэлгүй, шалгалтын босго тавихгүй байх нь тухайн албан тушаалын шаардлагыг хамгийн сайн хангасан иргэнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай зөрчилдөж байна гэж үзсэн болно.

Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тусгай шалгалт өгөх, болзол журмаар зохион байгуулах бөгөөд гагцхүү оролцогчоос авах шалгалтын агуулга, хэлбэр, үнэлгээг энэхүү журмаар зохицуулахаар төслийг бэлтгэлээ.

Шалгалтын агуулгыг 9 бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар тусгаж, боловсрол, туршлагад үнэлгээ өгч, тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг, дүн шинжилгээ хийх чадвар, асуудал шийдвэрлэх чадварын шалгалтын үнэлгээнд босго оноо тавьж, нийт онооны 60 хувиас дээш авсан тохиолдолд тэнцсэнд тооцохоор журмын төсөлд тусгасан нь төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалыг удирдах дээд албан тушаалд шаардлагад иошлүү их ач холбогдол өгсөн болно.

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.11 дахь заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулж байна.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төрийн захиргааны байгууллагын
төсвийн шууд захирагчийг сонгон
шалгаруулах журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын нэгдсэн үнэлгээний хуудас”-ны загварыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба, Салбар зөвлөлд тус тус даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журмын 1.3.1-д заасан төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцогчоос авах шалгалтын агуулга, хэлбэр, үнэлгээг энэ журмаар зохицуулна.

1.2.Төрийн захиргааны байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тусгай шалгалт өгөх, болзол журмаар зохион байгуулна.

Хоёр. Сонгон шалгаруулалтын агуулга, хэлбэр, үнэлгээ

2.1.Сонгон шалгаруулалтын агуулга дараах бүрэлдэхүүнтэй байна:

2.1.1.Оролцогчид албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж буй байдлын үнэлгээ;

2.1.2.тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг;

2.1.3.дүн шинжилгээ хийх чадвар;

2.1.4.асуудал шийдвэрлэх чадвар;

2.1.5.монгол хэлний бичгийн чадвар, цахим орчин, компьютерийн хэрэглээний програм ашиглах чадвар;

2.1.6.удирдан зохион байгуулах чадвар;

2.1.7.манлайлах чадвар;

2.1.8.багаар ажиллах чадвар

2.1.9.үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин.

2.2.Оролцогчид албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж буй байдлыг үнэлэхдээ оролцогчдын боловсрол, туршлага, ур чадварт дараах үнэлгээ өгнө:

2.2.1.Оролцогчдын боловсролын түвшинг бакалавр 5 оноо, магистр 8 оноо, доктор 10 оноо гэсэн үнэлгээгээр үнэлнэ.

2.2.2.Туршлагыг үнэлэхдээ албан тушаалын чиг үүрэг, салбарын чиглэлээр хамгийн олон жил ажилласан оролцогчийг 10 оноогоор үнэлж, энэ онооноос хувь тэнцүүлэн тооцох* замаар бусад оролцогчийн үнэлнэ.

2.3.Тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэгийг сорилоор шалгаж 30 хүртэл оноогоор үнэлэх бөгөөд 18 ба түүнээс дээш оноо авсан оролцогчийг дараагийн шалгалтад оруулна.

2.4.Дүн шинжилгээ хийх чадвар, асуудал шийдвэрлэх чадварыг сорил болон бодлогоор шалгаж тус бүр 10 хүртэл оноогоор үнэлэх бөгөөд тус бүр 6 ба түүнээс дээш оноо авсан оролцогчийг дараагийн шалгалтад оруулна.

2.5.Монгол хэлний бичгийн чадвар, хэрэглээний програм ашиглах чадварыг сорил, даалгавар, бодлого, зэргээр шалгаж тус бүр 10 хүртэл оноогоор үнэлнэ.

2.6.Удирдан зохион байгуулах, манлайлах, багаар ажиллах чадварыг ярилцлагаар шалгаж тус бүр 10 хүртэл оноогоор үнэлнэ.

2.7.Оролцогчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ сүүлийн гурван удаагийн үнэлгээнээс “Бүрэн хангалттай” үнэлгээнд 10, “Хангалттай” үнэлгээнд 7, “Хангалтгүй” үнэлгээнд 0 оноог тус тус өгнө.

2.8.Сул орон тоог нөөцөөс нөхөх шалгалтад энэ журмын 2.7 дах хэсэг хамаарахгүй болно.

2.9.Нийт онооны 60 ба түүнээс дээш хувь авсан тохиолдолд сонгон шалгаруулалтад тэнцсэнд тооцно.

---oO---